



ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ХҮРЭЭНД ХАМГААЛАГДААГҮЙ ЭРХ АШГИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

IDENTIFYING THE INTERESTS NOT PROTECTED WITHIN THE SCOPE OF CRIMES AGAINST PROPERTY RIGHTS

Борбаатарын Лодойсамбуу¹

Shihuhutug University, E-mail: lodoisambu@shihuhutug.edu.mn, <https://orcid.org/0009-0008-3329-470X>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

цахим хөрөнгө, хөрөнгө², эд
хөрөнгө³, эдийн бус хөрөнгө

Keywords:

cyber asset, property, tangible
property, intangible property

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 10 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Oct, 2025
Revised Oct, 2025
Accepted Oct, 2025

ХУРААНГУЙ

Өмчлөх эрх бол Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний баталгаатай эдлэх үндсэн эрх мөн гэж хуульчилсан байдаг. Сүүлийн жилүүдэд цахим технологийн хөгжил болон түүнээс үүдэлтэйгээр гарч буй шинэ төрлийн үнэ цэн бүхий хөрөнгүүд хэдийнээ хүмүүсийн хэрэглээнд нэвтрээд олон жилийг ардаа үлдээсэн боловч үүнээс үүдэлтэйгээр тухайн хөрөнгүүдийг хүний өмч хөрөнгө, баялаг мөн гэж эрх зүйн хүрээнд авч үзэх, цаашилаад хуулийн хамгаалалтад авах хэрэгцээ шаардлага байсаар байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуулиар өмчлөх эрхийн тодорхой хэлбэрүүд болох эдийн бус хөрөнгөд хамаарах эрх ашиг буюу хүний өмчлөх эрхийн тодорхой хэлбэрүүд тухайлбал цахим хөрөнгөд хамаарах дижитал объектууд хуулиар хамгаалагдахгүй байгаа нь өөрөө цахим гэмт хэргийн криминологи шинж буюу гэмт хэрэг үйлдэгдэх, давтагдан гарах зэрэг шалтгаан нөхцөл болж байгаа гэж үзэх боломжтой байгаа юм.

Энэхүү өгүүлэлээр Эрүүгийн хуулиар хамгаалагдаагүй эрх ашгийг тодорхойлох замаар цахим хөрөнгөд хамаарах гэмт хэрэг үйлдэгдэх тодорхой шалтгаан, нөхцөлийг арилгах боломжтой талаар өгүүлэх ба Эрүүгийн хуулийн “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” буюу Арван долдугаар бүлэгт нэмэлт өөрчлөлт оруулах зайлиггүй хэрэгцээ, шаардлага байгааг хууль зүйн үндэслэлтэйгээр тайлбарлах юм. Ингэснээр энэ нь хүний өмчлөх эрхийн баталгаатай хамгаалалт болж өгөхөөс гадна гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдэхгүй байх, гэмт хэргийг таслан зогсоох зэрэг криминологийн үндсэн асуудлыг шийдвэрлэх тодорхой гарц гаргалгаа мөн болох

¹ Шихихутуг их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш

² “ХӨРӨНГӨ” гэж хүний хийгээд улс оронд хамаарагдах өмч, үнэ бүхий зүйлийн нийт нэр, хөрөнгө гэх нь буй; **хөрөнгө чинээ, өмч хөрөнгө**; Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 2021он. 1035 тал.

³ “ЭД” гэж эдэлж хэрэглэж болох эдлэл юм, эд мэдэхгүй хүн эдийн нэр гутаах; эд агуурс, эд бараа, эд таваар, эд уурс, эд хогшил, **эд хөрөнгө** (хурааж цуглуулсан эд уурс); Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 2021он. 1262 тал.

талаас энэхүү судалгааг сийрүүлэв.

Abstract

The right to property is a fundamental human right guaranteed by the Constitution of Mongolia. In recent years, the rapid advancement of digital technologies has led to the emergence and widespread use of new forms of valuable assets in the digital space. However, despite their growing prevalence and economic significance, there remains a pressing legal need to recognize these assets as property and to ensure their protection under the law. Specifically, certain digital assets categorized as intangible property are not currently safeguarded under the Criminal Code of Mongolia, raising legal and criminological concerns.

This lack of legal protection has become one of the underlying criminogenic factors contributing to the commission and recurrence of cybercrime. In other words, the absence of explicit legal safeguards for digital objects that constitute a form of private property opens up opportunities for their exploitation through criminal means.

This paper aims to identify the types of interests—particularly those related to digital assets—that are not currently protected under criminal law. By examining the criminological causes and conditions that give rise to cybercrimes targeting such interests, this study seeks to provide a legal basis for addressing these gaps. Furthermore, it argues for the necessity of amending Chapter 17 of the Criminal Code of Mongolia, which governs crimes against property, to include offenses involving digital property. This would not only enhance the legal protection of ownership rights in the digital sphere but also serve as a meaningful step toward preventing, deterring, and ultimately reducing cybercrime through a criminological and legal framework.

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Өмчлөх эрх нь хүний үндсэн эрх, өмчийн харилцааны суурь зарчим бөгөөд түүнийг хамгаалах механизмууд хувийн ба нийтийн эрх зүйд өөр өөр байдлаар хэрэгждэг. Хувийн эрх зүйн хүрээнд өмчийн эрхийг Иргэний хууль, гэрээний эрх зүй, гэм хорын эрх зүй зэрэг харилцаагаар хамгаалж, өмчлөгч бусдад шаардах эрх эдэлдэг бол нийтийн эрх зүйн хүрээнд өмчийн эсрэг гэмт хэргээс хамгаалах үүргийг Эрүүгийн эрх зүйн зохицуулалт хариуцдаг. Өөрөөр хэлбэл, өмчлөх эрхэд халдсан хууль бус үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнд нийцэж буй тохиолдолд төр эрүүгийн хариуцлагын механизмаар өмчийг хамгаална.

Эрүүгийн эрх зүйн хамгаалалт үр нөлөөтэй хэрэгжихийн үндсэн нөхцөл нь өмчлөх эрхийн объект, өөрөөр хэлбэл эрх зүйн хамгаалалтад хамрагдах эд хөрөнгийг тодорхойлох явдал юм. Эдийн болон эдийн бус баялаг ямар шинжийг хангасан тохиолдолд өмчид тооцогдох, улмаар эрүүгийн хамгаалалтад багтах вэ гэсэн асуудал онолын болон практикийн түвшинд чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн харилцаа цахим орчин руу хүчтэй шилжиж, криптовалют, токен, дижитал актив зэрэг шинэ төрлийн цахим хөрөнгө бий болсноор өмчийн эрхийн уламжлалт ойлголт, түүнийг эрүүгийн эрх зүйгээр хамгаалах зарчмууд шинэ сорилттой тулгарч байна. Эдгээр хөрөнгө нь үнэ цэн бүхий, мөнгөөр үнэлэгдэх боломжтой боловч тэдгээрийн эрх зүйн статус, өмчлөх боломж, эргэлтэд орших нөхцөл, улмаар эрүүгийн хамгаалалт хамаарна эсэх нь тодорхойгүй хэвээр байна.

Ийм нөхцөлд өмчийн эрхийн онолын суурь, эд хөрөнгийн эрх зүйн үндсэн шинжүүд, цахим хөрөнгийн бүтэц ба нийтлэг онцлогийг шинжлэх нь өмчлөх эрхийн хамгаалалтыг орчин цагийн эдийн засгийн эргэлттэй нийцүүлэн боловсронгуй болгоход шаардлагатай юм. Энэхүү илтгэлд өмчлөх эрхийн объектын эрх зүйн шинж, цахим хөрөнгийн ангилал, эрх зүйн тодорхойгүй байдлаас үүдэх хамгаалалтын цоорхойг онол-практикийн түвшинд судлан тайлбарлахыг зорилоо.

2. Арга зүй

Энэхүү судалгаанд хууль зүйн догматик, харьцуулсан, онолын болон криминологийн аргыг хослуулан цахим хөрөнгийн эрх зүйн статус, өмчлөх эрхийн хамгаалалтын цоорхойг тодорхойлж, Эрүүгийн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагыг дүгнэв.

3. Судалгааны үр дүн

Өмчлөх эрхийг хамгаалахдаа хувийн болон нийтийн эрх зүйн хүрээнд хамгаалалт хийх боломжтой байдаг. Хувийн эрх зүй хүрээнд өмчийн эрх зүйгээр өмч хөрөнгийг тодорхойлох замаар гэрээний болон гэм хорын эрх зүйгээр шаардах эрхийг бий болгосноор өмч хөрөнгийг хамгаалдаг. Харин нийтийн эрх зүйн хүрээнд өмчийн хамгаалалт нь Эрүүгийн эрх зүйгээр хамгаалагддаг ба Өмчийн эсрэг гэмт хэрэг буюу бусдын өмчлөх эрхэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйгээр хуулиар хамгаалагдсан өмчлөх эрх ашигт нь халдсан тохиолдолд төрөөс хуулийн хүрээнд хамгаалах байдлаар хангагдаж байдаг.

Ингэхдээ хүний өмчлөлийн зүйл өмч хөрөнгийг тодорхойлох замаар эрх зүйгээр хамгаалагдах объектыг тодорхойлох, цаашлаад Эрүүгийн эрх зүйн хамгаалалтад хамаарах хүний өмчлөх эрх ашгийг зайлшгүй тодорхойлох шаардлагатай. Иймд хуулиар хамгаалагдах объектыг тодорхойлон авч үзье.

Хуулиар хамгаалагдах объектын шинжийг тодорхойлох

Эд хөрөнгө нь эрх зүйн хамгаалалтад орохын хүрээнд нийтлэг шинж чанартай байхыг шаарддаг. Эд юмсын шинжийг тодорхойлох замаар түүнд шинжлэх ухааны дүгнэлт хийж эрх зүйн хэм хэмжээ бий болгож хууль зүйн хамгаалалт бий болгосноор өмчлөх эрх хангагдаж эд хөрөнгийн эрхийн хамгаалалт бий болдог. Энэ хуульд шууд тусгаснаар бусдаас шаардах эрх үүсэх, хариуцлагын механизм бий болсноор эл эрх бүрэн хангагдаж байна гэж тодорхойлох боломжтой. Өмчийн эрх зүйд хуулиар хамгаалагдах объектыг дараах шалгууруудаар тодорхойлох боломжтой гэжээ.⁴ (Ц.Давхарбаяр, 2017)

⁴ Ц.Давхарбаяр “Эд баялгийн эрх эд юмсын эрх” 2017 он. 7 дэх тал..

Нэгдүгээрт: Эд юмсын эрх зүй бие даасан субьектив эрх болохыг тогтоож, үүнийг бусад эрхээс ялангуяа үүргийн эрх зүйгээс ялгах.

Хоёрдугаарт: Эд юмсын эрх зүйн үндсэн шинжийг тодорхойлон гаргах

Гуравдугаарт: Эд юмсын эрх зүйгээр зохицуулагдаж болох судалгааны объектыг тогтоох. Иргэний эрх зүй дэх өмч хөрөнгийн асуудлын эзлэх байр суурийг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн судлах.

Дөрөвдүгээрт: Эд юмсын эрх зүйг хамгаалах, түүнийг хэрэгжүүлэх механизмд анализ хийх замаар хамгаалах арга, зохицуулалтыг боловсронгуй болгох юм гэж судлаачид тодорхойлсон байна.

Эд хөрөнгө нь онолын хувьд дараах шинжүүдийг агуулсан тохиолдолд эрх зүйн хамгаалалтад орох боломжтой.

1. Материаллаг ба материаллаг бус байх шинж.

Эдийн болон эдийн бус баялгийн шинжийг тодорхойлох замаар эд хөрөнгийг тодорхой хэмжээнд ангилах хэрэгтэй. Биет хэлбэртэй хөрөнгүүдэд (газар, байшин, машин зэрэг), материаллаг бус хөрөнгөд (зохиогчийн эрх, цахим хэтэвч, хувьцаа, криптовалют, өөр бусад цахим үнэ цэн агуулж буй хөрөнгүүд) эдгээр хөрөнгүүд нь тодорхой хэмжээнд өөрийн гэсэн зах зээлийн үнэлгээтэй байхыг ёстой.⁵ (Б.Тэмүүлэн, 2010)

2. Өмчлөх боломжтой байх.

Хөрөнгө зайлшгүй өмчлөгчтэй байна. Ингэхдээ хуульд заасан үндэслэл журмын дагуу олж авсан, эрхийн зөрчилгүй буюу бусад этгээдээс шаардах эрх үүсэхгүй байх үндсэн шалгуурыг тавьдаг.

3. Худалдан борлуулах боломжтой байх.

Тухайн эд хөрөнгийг хуулийн дагуу худалдан борлуулах, ашиг олох бүрэн боломжтой байх ба эл эрхийг хэрэгжүүлэхэд ямар нэг саадгүй хэрэгжүүлэх боломжоор хангагдсан буюу бие даасан байх гэсэн шинж байх ёстой.

ИХ-ийн 243.1-т “Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь *биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбогдох баримт бичгийг.....*”⁶ гэсэн хуулийн заалт байна. Өөрөөр хэлбэл эрхийн зөрчилгүй гэдэг нь худалдан борлуулсны дараа гуравдагч этгээдээс шаардах эрх шаардлага гаргах боломжгүй байх ёстой.

4. Эрх зүй, хуулиар зохицуулагдсан байх.

Улс орнууд тухайн хөрөнгийг өмч гэж үзэж, зохицуулсан эсэхээс шалтгаалан тухайн хөрөнгийг өмч гэж тодорхойлох боломжтой эсэхээс хамааран хөрөнгө мөн гэж зохицуулах асуудал яригдана.

Манай улсын хувьд Иргэний хуулийн 83.1-т “Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь *хөрөнгө* болно” гэж хуульчилжээ

⁵ Б.Тэмүүлэн, Д.Энхзүл, Б.Буянхишиг “Иргэний эрх зүйн ерөнхий анги”. УБ хот. 2010он.

⁶ <https://legalinfo.mn/mn/detail/299>

5. Мөнгөөр үнэлэгддэг байх. /Monetary Value/

Энэ шинж нь өмч хөрөнгийн хамгийн том шинж бөгөөд өөрийн үнэ цэн нь тухайн нийгмийн хэрэглээний нэгжид шууд хөрвөх чадвартай байх ойлголт юм.

Monetary Value нь тухайн зүйл (жишээ нь: эд хөрөнгө, эрх, объект, дижитал хөрөнгө гэх мэт) нь мөнгөөр хэмжигдэхүйц байх үнэлгээтэй байх, өөрөөр хэлбэл **эдийн засгийн утга агуулсан байх** ёстой гэсэн үг юм.

Энэ нь тухайн зүйлд хөрөнгө болохын хувьд дараах боломжуудыг бий болгодог. Үүнд:

- Арилжаалагдах, худалдаалагдах эргэлтэд орох.
- Үнэлгээ хийх боломжтой буюу зах зээлийн журмаар өөрийн үнэ цэнийг бий болгодог.
- Эрх зүйн маргаанд шаардах эрх бий болгох. Өөрөөр хэлбэл шүүхээр эрхээ хамгаалуулах боломжуудыг бүрдүүлдэг.

Үүнээс үзэхэд Мөнгөөр үнэлэгдэх шинж нь Иргэний хууль болон олон улсын гэрээ, конвенцод зааснаар хүний эд хөрөнгө, өмч болоход хамгийн чухал шалгуур болох шинж тулгуур нөхцөл болох юм.

Цахим хөрөнгийн нийтлэг шинж болон онцлог.

Цахим хөрөнгийн хувьд биет хөрөнгөтэй харьцуулахад зохицуулалтын хувьд өөрөөр зохицуулах боломжтой. Хүмүүсийн хэрэглээнд нэвтэрсэн хөрөнгүүдийг нийтлэг байдлаар нь тодорхойлон 2 ангилалд хамааруулан авч үзэх боломжтой.

1. Хөрөнгөөр баталгаажсан цахим хөрөнгө.

Эдгээр ангилалд бидний сайн мэдэх хөрөнгийн хэлбэрүүд багтана. Үүнд:

- Хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас.
- Банкны карт болон хадгаламжийн дансанд буй мөнгө
- Үнэт баялгийг эзэмших эрх. Жишээлбэл: (XAUUSD) буюу алтыг цахим хэлбэрээр эзэмших эрхийг авах хэлбэр юм. Энэ нь брокерын байгууллагаар дамжуулан тухайн нэгж алтны өмчлөх эрхийг өөртөө авч байгаа явдал бөгөөд биет байдлаар өөртөө аваагүй ч зарж борлуулах, ашиг олох зэрэг эд хөрөнгийн эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой байх явдал юм.

2. Хөрөнгөөр баталгаажаагүй ч үнэ цэнэ агуулж буй цахим хөрөнгө.

- Криптовалют
- Цахим мөрийтэй тоглоомд байх хөрөнгө буюу зоос
- Цахим бооцоот тааварт байх хөрөнгө буюу зоос
- И-спортод хамаарах үнэ цэнэ агуулж буй зоос
- Тухайн ямар нэг үйлчилгээнд зориулсан онцгой эрх. Жишээлбэл: Автобусны карт, үзвэр үйлчилгээний ваучер бэлгийн карт, хөнгөлөлт урамшууллын купон код зэрэг багтах юм.

Хөрөнгөөр баталгаажаагүй ч үнэ цэнэ агуулж буй цахим хөрөнгүүд нь сүүлийн жилүүдэд илүү өргөжиж байгаатай холбоотойгоор эдгээрийг зохицуулах хэрэгцээ шаардлага байгаа гэж дүгнэх боломжтой. Эдгээр нь нийтлэг байдлаар өөрийн гэсэн зах зээлийг бүрдүүлж нийгмийн харилцаанд жин даахуйц байдал үүсгэж байгаа нь

тэдгээрийг тодорхойлох, хуулийн зохицуулалтад хамааруулах эсэхийг тодорхойлж өгөх хэрэгцээ шууд үүсгэж байна.

Цахим хөрөнгийн нийтлэг шинж:

Шинэ төрлийн цахим хөрөнгүүд нь нэг талаар ямар нэгэн үйл ажиллагааг зохицуулахаар бүтээгдсэн байдаг.

- Криптовалютын хувьд төлбөр тооцооны хэрэгслийн төрийн болон банкны хараат байдлыг халах буюу төвлөрсөн бус технологийг хэрэгжүүлэх, шилжүүлэг хийхэд түргэн шуурхай зардал багатай байх, мөн нөгөө талаар зах зээлийн журмаар эрэлт нийлүүлэлтийн хуулиар криптовалют сонирхож байгаа хүмүүсийн тоо нэмэгдэх тусам хязгаартай нөөц байгаа учир үнэ цэнэ нь илүү өссөөр байдаг.

- Цахим мөрийтэй тоглоом болон цахим бооцоот тааварт байх хөрөнгө нь бодит мөнгөтэй 1:1 хамааралтай буюу тухайн цахим платформд мөнгийг шууд орлох үүргийг гүйцэтгэдэг тухайн цахим тоглоомын хэрэглээний үүргийг гүйцэтгэдэг.

- Цахим спортод байх үнэ цэнэ бүхий хувцас, эд хэрэглэл нь тухайн доторх бодит амьдрал шиг гоё ганган харагдах, бусдаас илүү байх зэрэг хэрэгцээг хангадаг ба тоглоомон дотроо түүнийг худалдаж авах төлбөрийн хэрэгсэл /**Зоос**⁷ бий болгосон байдаг бөгөөд тэр нь төлбөрийн хэрэгсэл буюу мөнгөтэй шууд хамааралтай бус ялгаатай байдаг. Тухайлбал тоглоомд байх 1000ш зоос нь 30.000 төгрөгтэй тэнцэх буюу өөрөөр хэлбэл 30.000 төгрөгөөр худалдаж авах боломжтой гэсэн үг юм.

Үүнээс дүгнэн авч үзвэл:

1. Мөнгөөр орлогдох байдал. /Monetary Value/

Цахим хөрөнгүүд нь нийтлэг байдлаар заавал мөнгөөр худалдаж авах боломжтой байдаг. Харин эдгээрээс зарим хөрөнгийг эргүүлэн зарж мөнгө болгох боломжтой. Үүнд: Криптовалют, NFT, токен зэрэг багтдаг ба эдгээр нь бирж дээр үнээр байнга арилжигдаж байдаг тул Monetary Value-тай гэж үзнэ.

Харин дээр бусад хэрэглээний хөрөнгүүд нь шууд тодорхой үнээр мөнгөнд хөрвөх чадвар нь сул бөгөөд хүмүүс хоорондоо тохиролцох журмаар Арилжааны хэлцэл хийж худалдах тохиолдол байдаг.

2. Нийгмийн эсвэл тодорхой хүрээнд ямар нэг зүйлд үүрэгтэй байдал.

Цахим орчин дах харилцаа гэдэг бол нийгмийн амьдралын нэгээхэн хэсэг болсон өнөөгийн нийгэмд маш олон төрлийн хэрэглээний шийдлүүд бий болсоор байгаа. Сүүлд шинээр бий болж байгаа цахим хөрөнгүүд нь **хэрэглээнд нэвтэрсэн** байдлаараа цахим хөрөнгө мөн юм байна гэдэг тодорхойлолт үүсгэж болно. Тухайн зах зээлд хүмүүсийн хэрэгцээг хангаж байгаа байдал болон нийтээр хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэг нь цахим хөрөнгийг тодорхойлох нэг шалгуур мөн юм.

3. Ховор байдал буюу зах зээлийн эрэлтээр үнэлэгддэг байдал.

Тухайн цахим хэрэглээний ойлголт объект нь анх гарахдаа л юунд зориулагдсан, хэрхэн хэрэглэгдэх боломжтой, хэр баталгаатай, найдвартай байх зэрэг баталгааг

⁷ Тухайн тоглоом бүрээс хамааран өөр өөр нэршилтэй мөнгөтэй өөр өөр хамаарлаар харьцдаг зөвхөн өөрийн тоглоомонд л худалдан авалт болон өөр бусад хэлбэрээр ашиглах боломжтой цахим зоос юм. Жишээлбэл: PUBG Mobile тоглоомонд “UC” хэмээх нэгж зоос; Mobile legends тоглоомд “Diamond” хэмээх нэгж зоос, DOTA тоглоомд “Arcane”, CSGO тоглоомд “Skin” гэх мэт.

гаргасан буюу анхнаасаа тоглоомын дүрэм тодорхой байх явдал. Жишээлбэл: Биткойн бол мөнгөн төлбөрийн хараат байдлаас салах, төлбөрийн шилжүүлгийн шимтгэл зэрэг зардлаас сэргийлэх, түргэн шуурхай байх гэсэн үндсэн шинжээс гадна хамгийн гол нь **дэлхий дээр 21 сая ширхэг** л байхаар кодлогдсон нь энэ цахим хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ биткойны зах зээлийн үнэлгээг бууруулах, нэмж биткойн гаргаж зах зээл рүү нийлүүлэлт хийх эрсдэл байхгүй гэсэн үг буюу цэвэр эрэлт нийлүүлэлтийн хуулиар болон өөрийн гол үүргээрээ үнэ цэнээ мөнхөд хадгалах бүрэн боломжтой байгаа явдал юм.

Цахим хөрөнгийн онцлог тал:

Уламжлалт хөрөнгийг бодвол цахим технологийн хөрөнгөөс үүдэж буй хөрөнгүүд нь өөрийн үнэ цэнийг биет байдлаараа биш онцлог давуу тал болон нийгмийн хэрэгцээг хангаж буй байдал гүйцэтгэж буй үүргээрээ бүрдүүлж байдаг. Тодорхой ажлыг хийж байгаа байдлаараа бодит үр дүнгээрээ өөрийгөө улам үнэ цэнтэй болгож байгаа оюуны үнэ цэнэ бүхий зүйл болж байгаа юм.

Иймд шинэ төрлийн цахим хөрөнгүүд нь дээр дурдсан шалгуурыг хангаж байгаа тохиолдолд хуулиар хамгаалагдах объектын шинжийг хангаж байна гэж дүгнэнэ.

Эрүүгийн хуулиар хамгаалагдаагүй хүний өмчлөх эрх, ашиг

Монгол улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэг “**Хүний эрх, эрх чөлөө**” арванзургадугаар зүйлд- Монгол улсын иргэн дараах **үндсэн эрх, эрх чөлөөг** баталгаатай эдэлнэ. Арванзургадугаар зүйлийн гурав дах хэсэгт “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно.”⁸ гэж Үндсэн хуульчилсан байна.

Үүнээс улбаалан хүний эд хөрөнгийн эрхийг Монгол улсын Иргэний хуулийн 83.1-т “Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно” гэж хуульчилжээ. Цахим хөрөнгүүд нь эдийн бус баялаг гэж тооцогдохын хүрээнд хуулиар хориглоогүй байх, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй байх гэсэн шалгуурыг хангах шаардлагатай байхаар хуульд ерөнхий байдлаар тусгасан байна.

Тиймээс хэрэглээнд нэвтэрсэн цахим хөрөнгүүдийг эл шинжийг хангаж байгаа байгаа эсэхээр баялаг мөн эсэхийг тодорхойлох боломжтой ч зарим нэг асуудал тулгарч байна. Тухайлбал:

1. **Хуулиар хориглоогүй байх** гэдэг шинжийг хүрээнд авч үзье. Шинэ төрлийн хөрөнгүүдийг тэр бүр хориглож, зөвшөөрөх эсэхийг хуульчлаад байх боломж хязгаарлагдмал. Эд баялаг, өмч хөрөнгөтэй холбоотой харилцаа нь хувийн эрх зүйд хамаарахын хувьд хориглосноос бусдыг зөвшөөрөх зарчмын ойлголтоор зохицуулах боломжтой. Өөрөөр хэлбэл эдийн бус баялаг цахим хөрөнгө гэж нарийн тодорхойлох боломжгүй гэж авч үзвэл заавал тодорхойлох гэхээсээ илүүтэйгээр ийм шинжийг

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

хангаагүй тохиолдолд эдийн бус баялаг гэж үзэхгүй гэсэн хориглосон зохицуулалт оруулах байдлаар хүрээ хязгаар тогтоох боломжтой.

2. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүй байх гэсэн шинжийн хүрээнд авч үзье. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ гэж юуг ойлгох вэ? Энэ нь нэгдүгээрт тухайн зүйлийг бүх нийтээр хүлээн зөвшөөрөх тухай, хоёрдугаарт тухайн харилцаанаас үүсэх үр дагавар нь шударга ёсны зарчимд нийцэж, бусдад шаардах эрх үүсэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй байх тухай ойлголт юм. Хэрэглээнд нэвтэрсэн цахим хөрөнгийн төрлүүдийг энэ шинжид хамааруулан авч үзвэл уг шинж хангагдах эсэх тун эргэлзээтэй байна.

Мөн Иргэний хуулийн 84.5-д “Эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл нь **эдийн бус хөрөнгөд** хамаарна.” гэж хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл шинэ төрлийн цахим хөрөнгүүд нь эдийн бус хөрөнгөд хамаарна гэж хуульчилсан байна.

Хоёр. Хамгаалагдаагүй эрх, ашиг түүний эрх зүйн үр дагаврыг тодорхойлох, эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Эрүүгийн хууль.

Үүнээс дүгнэн үзвэл өмчлөгчийн эрхийг зөрчих аливаа халдлага нь гэм буруутай эсэх, гэмт хэргийн шинжтэй эсэх, гэмт үйлдэл байх эсэхээс үл хамааран эрх зүйн хамгаалалтаар зайлшгүй хамгаалагдана.

Ингэхдээ Эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдахын хувьд Эрүүгийн хуульд заасан хамгаалагдсан эрх ашигт өмчлөх эрх багтаж байгаа эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Эрүүгийн хуулийн Арвандолдугаар бүлэг “**Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг**”-т хамаарах хамгаалагдаж байгаа эрх ашиг мөн эсэхийг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүснэ.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хамгаалагдаж буй эрх ашиг /**объект**/ нь **өмч хөрөнгө** байдаг. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн объектоо шинжийг болон хамгаалагдаж байгаа эрх ашиг /**объект**/-г авч үзье.

Эрүүгийн хуулийн Арван долдугаар бүлэг:

- 17.1 дүгээр зүйл. Хулгайлах гэмт хэрэг. “Бусдын эд **хөрөнгийг** хүч хэрэглэхгүйгээр,...”,

- 17.2 дугаар зүйл. Дээрэмдэх гэмт хэрэг. “Бусдын эд **хөрөнгийг** илээр,...”,

- 17.3 дугаар зүйл. Залилах гэмт хэрэг. “Хуурч, эсхүл баримт бичиг,..... өмчлөгчийн эд **хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг** шилжүүлэн авсан бол...”,

- 17.4 дүгээр зүйл. Хөрөнгө завших гэмт хэрэг. “Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд **хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг** завшсан бол...”,

- 17.5 дугаар зүйл. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг. “.... эд **хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө...**”,

- 17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг. “Бусдын эд **хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхээ ...**”,

- 17.7 дугаар зүйл. Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэрэг.

- 17.8 дугаар зүйл. Эд хөрөнгө устгах, гэмтээх гэмт хэрэг. “Бусдын эд **хөрөнгийг** устгасан,...”,

- 17.9 дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах гэмт хэрэг. “Бусдын эд хөрөнгийг хадгалах...”,

- 17.10 дугаар зүйл. Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих гэмт хэрэг. “.....бусдын эд хөрөнгө, эдийн, эдийн бус хөрөнгийн эрхэд...”,

- 17.11 дүгээр зүйл. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх гэмт хэрэг. “Бусдын эд хөрөнгөд...”,

- 17.12 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэг гэсэн 12 өмчлөх эрхийн гэмт хэргийг Эрүүгийн хуулиар хуульчлан хамгаалжээ.

Дээрх гэмт хэргүүдийн хамгаалагдаж буй эрх ашиг буюу объект бүгд материаллаг буюу эд хөрөнгийг, Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг болон 17.10 дугаар зүйл. Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих гэмт хэрэгт эдийн бус хөрөнгийг хамгаалахаар тусгажээ.

Өөрөөр хэлбэл “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-г хамаарах 12 гэмт хэргийн хамгаалагдаж буй эрх ашиг нь ЭД ХӨРӨНГӨ байна.

Үүнээс дүгнэн үзвэл “Эд хөрөнгө” гэж юуг тодорхойлох эсэхийг Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д:

- “Эд” гэж эдэлж хэрэглэж болох биет зүйлийг ойлгоно гэж тодорхойлсон байна.
- Харин “Хөрөнгө” гэж хүний хийгээд улс нийгэмд хамаарагдах өмч үнэ бүхий зүйлийн нийт нэрийг ойлгоно.

Эрүүгийн хуулиар өмчлөх эрхийг хамгаалахдаа хүний баялаг, хөрөнгийг халдашгүй байдал Үндсэн хуульд заасан эл эрхийг хангаж, хамгаалах ёстой билээ.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүний өмч хөрөнгийг хамгаалахдаа Эд хөрөнгийг хамгаалах, зарим талаар эдийн бус хөрөнгийг 2 зүйл гэмт хэрэгт л хамгаалж болохоор хуульчилжээ.



Схем 1.

Өмчийн эсрэг гэмт хэргийн хуулиар хамгаалагдах эрх, ашиг нь хүний өмч хөрөнгө байх ёстой. Онолын хувьд: Сонгодог онол⁹, Байгалийн эрхийн онол¹⁰, Хууль зүйн

⁹ Энэхүү онол нь “Өмчлөх эрхийн хувь хүний заяагдмал салиггүй эрх”⁹ гэж үздэг онол юм. Ж.Локк, Ш.Монтескье, А.Смит зэрэг сэтгэгчид өмчлөх эрхийг хүн төрөлхтний төрөлхийн эрхүүдийг нэг хэсэг юм гэсэн хандлагыг барьдаг. Сонгодог онолын дагуу өмчлөх эд хөрөнгийн эрхийг төр ямар нэг байдлаар хязгаарлах ёсгүй гэж үздэг. Өөрөөр бол хүний эд хөрөнгө нь хуулиар заасан хэмжээнд ямар нэг байдлаар хамгаалагдах юм яригдана.

позитивизм¹¹, зэрэг өмчийн онолууд нь өмч хөрөнгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун нь гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлан, тодорхой онош тогтоосны үндсэн дээр түүнтэй тэмцэх, үр өгөөж бий болгох зорилготой байдаг (Долу, 2022 он.) Уг үзэл санаагаар бол гэмт явдал, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг олж тогтоох нь эцсийн зорилго болох юм.

Өмч бидний бие махбод, хөдөлмөр, эд хөрөнгөө өмчлөх эрхийг нөхцөлдүүлдэг учир уг эрхэнд халдсан түүнийг зөрчсөн аливаа үйлдэл шударга бус. Хувь хүний хууль ёсоор өмч олж авах, хэрэглэх, буцаан өгөх эрхийг хүндэтгэн үзээгүй цагт дээрх эрхүүд хэрэгжих боломжгүй (Б.Мөнх-Эрдэнэ, 2021)

Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд цахим орчны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор нийгмийн харилцаа цахим орчинд явагдах нь ихэссэн. Эрүүгийн хэргийн шүүхэд цахим үнэ цэн бүхий хөрөнгөтэй холбоотой нэлээдгүй хэргүүд дэнслэгдсээр байгаа ба үнэхээр цахим орчинд хөрөнгөө алдсан, залилуулсан өмч хөрөнгөд нь хохирол бодитой учирсан гэх хэргүүдэд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжгүй байна гэж хэрэг хаагдсаар байна. Тухайлбал Улсын Дээд Шүүхийн тогтоол бүхий 2 хэргийг жишээ болгож оруулав.¹²

Яагаад гэмт хэргийн шинж хангагдахгүй байгаа гэдэг нь хамгаалагдаж байгаа эрх ашгийг нь */Эдийн бус хөрөнгө/* Эрүүгийн хуульд тусгаж өгөөгүй нь өөрөө хуульд заагаагүй тохиолдолд гэмт хэрэг биш гэж үзэх боломжтой. Үүний үр дагаварт иргэдийн хуулиар заавал хамгаалагдах эрх, ашиг зөрчигдсөөр иргэд хохирсоор байгаа билээ.

Эрүүгийн хуульд гэмт хэргийг хэр зэрэг оновчтой ялгаж тодорхойлсон болон үйлдэл болгонд оногдуулах ял шийтгэлийн төрөл, хэмжээг нийгмийн хор аюулын шинж чанарт тохирсон байдлаар тогтоосноос тухайн улсын эрүүгийн бодлогын үр нөлөө шалтгаалдаг гэсэн үзэл баримтлал зонхилж байна. Үүнд криминологийн онол, судалгаа

Цахим хөрөнгийг уг онолтой холбон авч үзвэл хууль ёсоор эзэмшил, өмчлөлдөө шилжүүлэн авсан аливаа эд баялаг нь түүний заяагдмал хөрөнгө гэж тодорхойлох боломжтой буюу эд хөрөнгөтэй холбоотой урган гарах нийгмийн асуудалд хамааруулан авч үзэх, эрх зүйн хамагалалтад байх объект мөн гэж тодорхойлох боломжтой.

¹⁰ Жон Локк (John Locke) “Өмчлөх эрхийг хүний төрөлхийн эрх юм.”¹⁰ гэж үзсэн. Энэ нь Хүн хөдөлмөрөөрөө аливаа баялагийг бүтээдэг бөгөөд түүнийгээ шударгаар өмчилж, хамгаалуулах ёстой гэж тайлбарласан онол юм. Энэ онолоор өмчийн эрх төрөөс үл хамааран оршин байдаг бөгөөд хувь хүний өмчийн эрхийг дээдлэн хамгаалах хэрэгтэй гэсэн үзэл санаа илэрч байдаг.

¹¹ Жерemi Бентам (Jeremy Bentham) “Өмчийн эрхийг зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд хүлээн зөвшөөрдөг”¹¹ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл төр өмчийн эрхийг баталгаажуулах хамгаалах үүрэгтэй бөгөөд өмчийн эрх зөвхөн хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр оршдог.

Энэ үзэл санаа нь дэлхийн улс орнуудын дийлэнхд нь тусгалаа олон хэрэгждэг ба манай улс ч мөн өмчийн эрх зүйгээр түүнд нийцүүлэн Үндсэн хууль болон Иргэний хуулиар өмч болон түүнд хамаарах бусад эрхүүдийг хуульчлан зохицуулж өгсөн байдаг.

¹² 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдөр, Дугаар: 001/ХТ2025/00003 УДШ-ийн Тогтоол

https://www.supremecourt.mn/mn/printc?id=44995&fbclid=IwY2xjawJuWnpleHRuA2F1bQIxMAABHn1sSnZ3fZEjfsTu4JWj-NWb-DFm1JYuzJqd4GQcA_2dLpvmqsjidaUJRCJt_aem_ZLhjOy_qFr_Yyy8rLiWPNg

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Дугаар: 2024/ХИШТ/127 УДШ-ийн Тогтоол

https://shuukh.mn/single_case/3636?daterange=2024-01-01%20-%202025-04-18&id=3&court_cat=2&bb=1

өнөөг хүртэл хуримтлагдсан мэдлэгийн сан нэн чухал ач холбогдолтой. (Д.Зүмбэрэлхам, 2022)

Түрүүн дурдсанчлан цахим хөрөнгөд хамаарах гэмт хэргүүдийн эрүүгийн эрх зүйд нөлөөлөх, жин даах байдал нь өдөр ирэх бүр нэмэгдсээр байгаа энэ үед уламжлалт хөрөнгийн /эд хөрөнгө/ эрх зүйн хамгаалалтын хажууд цахим хөрөнгийн /эдийн бус хөрөнгө/ хуулиар хамгаалагдах байдал нь орхигдсон гэж харагдаж байна.

Энэ нь Эрүүгийн хуулийн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамгаалагдаж буй эрх ашигт /Объект/ эдийн бус хөрөнгийг тусгаж өгөөгүйгээс үүдэлтэй гэмт хэрэг үйлдэгдэх дараах шалтгаан нөхцөл үүсэж байна. Үүнд:

1. Цахим хөрөнгөд хамаарах гэмт хэргүүд “Гэмт хэргийн шинжгүй” гэж үзэх Эрүүгийн хуулийн үндэслэлтэй байгаа тул гэмт хэрэг шууд үйлдэгдэх.

2. Гэмт хэрэг үйлдэгдсэн, гэм буруутай этгээд бусдын цахим хөрөнгөд халдсан боловч гэм буруутайд тооцогдохгүй, ял завших боломжтой байдал нь гэм буруутай этгээдэд дахин гэмт хэрэг үйлдэх сэдэл, зорилго бий болгох.

3. Зохион байгуулалттай байнга гэмт хэрэг үйлдэх боломжийг бүрдүүлэх.

4. Гэмт явдал, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг өөхшүүлэх, тэдгээр нь дураар авирлах, бусдын шударга хөдөлмөрөөр олсон хөрөнгөд хууль бусаар халдах, их хэмжээгээр хохироох зэрэг Криминологийн шинжүүд, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлүүд тогтоогдож байна.

Эрүүгийн хуулийн арван долдугаар бүлэгт байх хамгаалагдсан эрх ашигт нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага нь энэ илтгэлийн маань үндсэн агуулга, судалгаагаар нотлогдож байх тул өмчлөх эрхийн хамгаалагдаж буй эрх, ашгийг дутуу тодорхойлж зохицуулалт хийсэн нь цахим гэмт хэрэг үйлдэгдэх криминологийн гол шалтгаан нөхцөл болж байна гэж дүгнэх нь үндэслэлтэй юм.

4. Дүгнэлт

Өмчлөх эрх гэдэг бол Үндсэн хуулиар олгогдсон хүний үндсэн эрх билээ. Өөрийн шударгаар олж авсан хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах явцад гэмт халдлагад өртөж өмчлөх эрх нь зөрчигдсөн бол Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3,4 дэх хэсэгт зааснаар эрхээ хамгаалуулах эрхтэй байна. Өмчлөх эрхийг хувийн болон нийтийн эрх зүйгээр хамгаалдаг ба нийтийн эрх зүйн хамгаалалт нь Эрүүгийн эрх зүйн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хамгаалагдаж буй эрх, ашиг байна.

Өмчлөгчийн эрхийг зөрчих аливаа халдлага нь гэм буруутай эсэх, гэмт хэргийн шинжтэй эсэх, гэмт үйлдэл байх эсэхээс үл хамааран Эрүүгийн эрх зүйн хамгаалалтад орно. Ингэхдээ Эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдахын хувьд Эрүүгийн хуульд заасан хамгаалагдсан эрх ашигт өмчлөх эрх багтаж байгаа эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Эрүүгийн хуулийн Арван долдугаар бүлэг “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т хамаарах хамгаалагдаж байгаа эрх ашиг мөн эсэхийг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүснэ. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хамгаалагдаж буй эрх ашиг /объект/ нь **өмч хөрөнгө** байдаг. Гэтэл “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 12 гэмт хэргийн хамгаалагдаж буй эрх, ашиг нь **ЭД ХӨРӨНГӨ** байна.

“Нэгтгэн дүгнэвэл Монгол улсын Эрүүгийн хуулиар хүний өмчлөх эрхийг хамгаалахдаа “Эд хөрөнгө”-ийг л хамгаалсан бөгөөд “Эдийн бус хөрөнгө”-г шууд хамгаалаагүй байгаа нь өмчлөх эрх бүрэн хамгаалагдаагүйн сацуу цахим гэмт хэргийн криминологи шалтгаан, нөхцөл шууд болж байна гэж дүгнэлээ.

1. Энэхүү судалгаагаар өмчийн эрх зүйн хүрээнд цахим хөрөнгө буюу эдийн бус хөрөнгө гэж тодорхойлогдох шинжийг авч үзэж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл өмчлөх эрхийн хүрээнд судалгааны ажлынхаа хүрээ хязгаарыг тогтоосон болно. Учир нь өмчлөх эрхийн хүрээнд цаашдаа эдийн бус хөрөнгийн асуудлыг нарийвчлан тодорхойлох хэрэгцээ шаардлага зүй ёсоор үүсэж байгаа юм. Үндсэн эрхээ хэрэгжүүлэх буюу өмчлөх эрхийг хамгаалахын тулд эдийн бус хөрөнгө, түүний дотор цахим хөрөнгөтэй холбоотой зөрчигдөж буй эрхийг сэргээх харилцааг ойлгомжтой болгох нь цаг үеийн зайлшгүй шаардлага болон гарч иржээ. Иймд эдийн бус хөрөнгөд цахим хөрөнгө гэх ойлголт багтаж байгааг энэхүү саналаар дэвшүүлж байна.

2. Эдийн бус хөрөнгийг хувийн эрх зүйн харилцаагаар хамгаалаад зогсохгүй нийтийн эрх зүйн хүрээнд анхаарч хамгаалах шаардлага бий. Тэр дундаа Монгол Улсын эрүүгийн эрх зүйд өмчлөх эрхийн эсрэг гэмт үйлдэл, эс үйлдэхүйг хуульчлахдаа зөвхөн эд хөрөнгийг хамгаалахаар зохицуулалт хийгдсэн нь эдийн бус хөрөнгийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй байгааг илтгэнэ. Цаашид өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн хамгаалагдсан эрх ашигт эд хөрөнгийн болоод эдийн бус хөрөнгийг багтааж хуульчлах, хууль хэрэглээнд нэвтрүүлэх шаардлага бий болжээ.

5. Эх сурвалж

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Иргэний хууль. 2002
- Эрүүгийн хууль. 2015
- Б.Мөнх-Эрдэнэ. (2021). Гэмт хэрэг судлалын онол. УБ: Өнгөт талст.
- Б.Тэмүүлэн, Д. Б. (2010). Иргэний эрх зүйн ерөнхий анги. УБ.
- Д.Зүмбэрэлхам. (2022). Криминологийн онол. УБ: Соёмбо Принтинг.
- Долу, О. (2022 он.). Криминологийн онолууд. УБ: Бэмби сан.
- Ц.Давхарбаяр. (2017). Эд баялгийн эрх зүй. УБ: Мөнхийн үсэг.
- Я.Цэвэл. (2021). Монгол хэлний товч тайлбар толь. УБ: Мөнхийн үсэг.
- <https://legalinfo.mn/mn/detail/299>
- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- https://shuukh.mn/single_case/3636?daterange=2024-01-01%20-%202025-04-18&id=3&court_cat=2&bb=1
- https://www.supremecourt.mn/mn/print?id=44995&fbclid=IwY2xjawJuWnpleHRuA2F1bOIxMAA_BHn1sSnZ3fZEjfsTu4JWj-NWb_DFm1JYuzJqd4GOcA_2dLpvmqsjdaUJRCJt_aem_ZLhjOy_qFr_Yyv8rLiWPNg